



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1/142

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх,  
үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах  
журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,  
Эрүүл ахуйн тухай хуулийн 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /С.Өнөрсайхан/-д тус тус даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүжилтийг жил бурийн төсөвт тусгаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/585 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

С.ЧИНЗОРИГ

С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын  
2023 оны 04 сарын 14.-ны өдрийн  
4/142 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (цаашид үнэлгээ гэх) нь үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжихэд чиглэнэ. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

### ХОЁР. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүн, тайланд санал, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний Зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ ажиллана.
- 2.2 Зөвлөл нь эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга ба гишүүд гэсэн бүтэц, бүрэлдэхүүнтэй байна.
- 2.3 Зөвлөлийн бүрэлдэхүүн, нарийн бичгийн даргыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилон ажиллуулж, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга ахлан ажиллана.
- 2.4 Зөвлөл нь Ажлын албатай байх бөгөөд Ажлын албаны бүрэлдэхүүнийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Захирал батална.
- 2.5 Үнэлгээг дараах тохиолдолд хийнэ:
  - 2.5.1 Хүн амын суурьшлын бүсийг төлөвлөж барилгажуулах үед
  - 2.5.2 Нийтийн эдэлбэр, гэр хорооллын газрыг дахин төлөвлөх үед
  - 2.5.3 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй болон нөлөөлсөн үед
- 2.6 Үнэлгээ хийх сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллага Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлалын дагуу үнэлгээг хийж гүйцэтгэнэ.
- 2.7 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй болон нөлөөлсөн тохиолдолд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын шийдвэрээр үнэлгээ хийх мэргэжлийн баг бүрдүүлж ажиллуулж болно.
- 2.8 Үнэлгээний үйл ажиллагаанд оролцогч талууд (захиалагч, үнэлгээ хийх аж ахуй нэгж, ажлын алба)-ын хооронд гурвалсан гэрээ байгуулан ажиллана.
- 2.9 Үнэлгээний дүгнэлтэд үндэслэн гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 20 дугаар зүйл, Эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

## **ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Зөвлөл нь анагаах ухаан, байгалийн ухаан, хор судлал, орчны болон нийгмийн эрүүл мэндийн салбар, төрийн бус болон хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 3.2 Зөвлөл нь ажлын албанаас ирүүлсэн үнэлгээ хийх ажлын чиглэл, аргачлал, зардал, төлөвлөгөөг батлана.
- 3.3 Зөвлөл нь үнэлгээний тайлантай танилцаж, хүлээн авах, татгалзах, сайжруулах санал бүхий шийдвэр гаргана. Үүнд:
  - 3.3.1 Үнэлгээний тайлан шаардлага хангаагүй, зардал бодит бус, нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд татгалзах
  - 3.3.2 Зарим шаардлагатай нэмэлт тодруулга авах, өөрчлөлтийг тусгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сайжруулах зөвлөмж өгөх
- 3.1 Үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар улирал тутамд, цаг үеийн асуудлаар тухай бүрт хуралдана.
- 3.2 Эрүүл ахуйн тухай хуулийн 9.6-д заасны дагуу эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх чиглэлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй зарлана.
- 3.3 Зөвлөлийн гишүүд, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу мэдүүлэг гаргаж өгнө.
- 3.4 **Зөвлөлийн хурлын дэг, шийдвэр гаргах**
  - 3.4.1 Хурлаар хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг зөвлөлийн нарийн бичгийн дарга боловсруулж, зөвлөлийн даргаар батлуулна.
  - 3.4.2 Зөвлөлийн хурал товлогдсоноос 3-аас доошгүй хоногийн өмнө Ажлын алба хэлэлцүүлэх асуудлын дэлгэрэнгүй мэдээлэл, дүгнэлтийг зөвлөлийн нарийн бичгийн дарга гишүүдэд хүргүүлсэн байна.
  - 3.4.3 Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, Зөвлөлийн дарга баталгаажуулж, гарын үсэг зурна.
  - 3.4.4 Хурлыг гишүүдийн 70%-иас доошгүй ирцтэй, нээлттэй, ил тод хийнэ.
  - 3.4.5 Гишүүдийн саналыг илээр хураах ба хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар зөвшөөрсөн тохиолдолд тухайн хэлэлцэх асуудал дэмжигдсэнд тооцож шийдвэрийн төслийг танилцуулж, зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
  - 3.4.6 Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй тохиолдолд Зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэж, түүнийг төлөөлж хуралд оролцох албан тушаалтыг хуралд оролцуулах, төлөөлж оролцох боломжгүй тохиолдолд хэлэлцэж буй асуудалд бичгээр саналаа ирүүлсэн тохиолдолд тухайн гишүүнийг ирцэд бүртгэж, саналыг шийдвэрлэлтэд харгалзан үзнэ.

## **ДӨРӨВ. АЖЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ҮҮРЭГ**

- 4.1 Ажлын алба дараах үйл ажиллагааг зохион байгуулна.
  - 4.1.1 Үнэлгээ хийх ажлын чиглэл, зардал, төлөвлөгөөг боловсруулан жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
  - 4.1.2 Ажлын алба нь эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх тухайн чиглэлийн аргачлалыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтийг Зөвлөлд хүргүүлнэ.
  - 4.1.3 Эрүүл ахуйн тухай хуулийн 5.2, 9.1-д зааснаас гадна хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй болон нөлөөлсөн нөхцөлд үнэлгээ хийх шаардлага хангасан байгууллагыг сонгон шалгаруулна.
  - 4.1.4 Сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагад үнэлгээний ажлын даалгавар, удирдамж боловсруулж, санал зөвлөмж өгнө.
  - 4.1.5 Үнэлгээний тайланг хүлээн авч, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлт гарган ажилана.
  - 4.1.6 Үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага, албан тушаалтан, судлаач, шинжээч нь ашиг сонирхлын зөрчлийн улмаас хууль тогтоомж, шинжлэх ухааны үндэслэлгүй буруу ташаа үр дүн, дүгнэлт гаргасан нь нотлогдсон тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
  - 4.1.7 Үнэлгээний чиглэлээр чадавхжуулах сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулна.
  - 4.1.8 Үнэлгээний мэдээллийг нээлттэй болгох зорилгоор мэдээллийн санг хөтлөх, баяжуулах үйл ажиллагааг хариуцан ажилана.
  - 4.1.9 Иргэн, аж ахуйн нэгжийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг судалж, ажлын 14 хоногийн дотор хариуг холбогдох байгууллагад албан бичгээр мэдэгдэх
  - 4.1.10 Үнэлгээ хийх явцад хяналт тавьж, санал зөвлөмж өгөх ,
  - 4.1.11 Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн боловсруулсан нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих
  - 4.1.12 Захиалгчийн болон үнэлгээ хийсэн байгууллагын техник, технологи, бизнесийн холбоотой мэдээллийн нууцыг хадгалах

## **ТАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 5.1 Үнэлгээний тайлан дараах мэдээллийг агуулсан байна.
  - 5.1.1 Байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийг харьцуулсан судалгаа төлөв байдлын шинжилгээ
  - 5.1.2 Тухайн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд учирч болзошгүй болон учирсан эрсдэлийн цар хүрээний дүн шинжилгээ
  - 5.1.3 Эерэг нөлөөллийг дэмжих, сөрөг нөлөөллийн үр дагавар түүнээс зайлсхийх бууруулах боломжит хувилбарыг тусгасан нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө

- 5.1.4 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргуйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд
- 5.1.5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд үзүүлэх эерэг нөлөөлөл үр дүн
- 5.2 Ажлын алба нь үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хангаж үнэлгээний үр дүнг нягтлан хянаж, захиалагч байгууллага болон шийдвэр гаргагчид орон нутгийн удирдлага, ард иргэдэд танилцуулна.
- 5.3 Үнэлгээний тайланг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд үнэлгээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд, үнэлгээг захиалсан байгууллагын төлөөллийг оролцуулж, тодруулга авч болно.
- 5.4 Гүйцэтгэгч нь захиалагчтай хийсэн гэрээ болон ажлын даалгаварт тусгагдсан асуудлыг тайланда бүрэн тусгана.
- 5.5 Тайланд үнэлгээний явцад бүрдүүлсэн маягт, тайлбар бүхий фото зураг, видео бичлэг, дагалдах мэдээллүүд, загварчлал, тооцооллуудын эх баримтуудыг багтаасан байна.

## **ЗУРГАА. ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН**

- 6.1 Үнэлгээний мэдээллийг нээлттэй болгох зорилгоор ажлын алба нь эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн санг байгуулна.
- 6.2 Мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:
  - 6.2.1 Үнэлгээтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг
  - 6.2.2 Үнэлгээний тайлангийн товч танилцуулга
  - 6.2.3 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн талаарх тайлан
- 6.3 Мэдээллийн нэгдсэн санг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд нээлттэй ажиллана.
- 6.4 Үнэлгээний тайлан, зөвлөлийн шийдвэрийг архивлаж, үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын албанад 5 жил хадгална.

## **ДОЛОО. САНХҮҮЖИЛТ**

- 7.1 Зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зардлыг жил бүрийн Улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.
- 7.2 Энэхүү журмын 2.5-д заасны дагуу үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргасан захиалагч байгууллага нь шаардагдах зардлыг хариуцна.

Эрүүл мэндийн сайдын  
2023 оны 09 сарын 14-ны өдрийн  
11/12 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГА, БАГИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (цаашид үнэлгээ гэх) хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар захицуулна.

### ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Эрүүл ахуйн тухай хуулийн 9.6-д заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Зөвлөл нь үнэлгээ хийх чиглэлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах ба сонгон шалгаруулалтад оролцох гүйцэтгэгчийн хүсэлт, шаардагдах материалыг Ажлын албанд заасан хугацаанд ирүүлнэ.
- 2.2 Ажлын алба нь сонгон шалгаруулахтай холбоотой асуудлаар гүйцэтгэгч болон түүний эрх ашгийг төлөөлж байгаа аливаа байгууллага, хувь хүний нөлөөнд автахгүйгээр үйл ажиллагаагаа ил тод явуулна.
- 2.3 Ажлын алба нь сонгон шалгаруулалтаар шалгарсан гүйцэтгэгчийн ажлын явц, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих, талуудад албан шаардлага тавих, хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргах эрхтэй.
- 2.4 Үнэлгээ хийх гүйцэтгэгч нь үнэлгээний дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой шийдвэрийг хариуцах чадвар бүхий дараах хуулийн этгээд хамаарна.
  - 2.4.1 Мэргэжлийн байгууллага
  - 2.4.2 Судлаач, шинжээчдийн холбоо
  - 2.4.3 Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллага
- 2.5 Үнэлгээний багийн гишүүд нь үнэлгээг хийх, дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээр мэргэшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.
- 2.6 Үнэлгээний ажлын онцлог, цар хүрээ, үйл ажиллагаанаас хамаарч үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнд тархвар судлаач, хүний их эмч, хүнс, хүүхдийн эрүүл ахуйч, орчны ба хөдөлмөрийн эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэнд судлаач, социологич, химич, биоанагаах судлаач, цөмийн болон био физикч, хор судлаач болон бусад мэргэжилтнүүдийг оролцуулна.
- 2.7 Үнэлгээ хийх баг, аж ахуйн нэгж нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу мэдүүлэг гаргаж өгнө.
- 2.8 Сонгон шалгаруулалтад оролцох байгууллага дараах баримтыг бүрдүүлж нууцлан ирүүлнэ. Үүнд:
  - 2.8.1 Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт

- 2.8.2 Гүйцэтгэгчийн товч танилцуулга
  - 2.8.3 Үнэлгээний ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан, материаллаг баазын чадавхыг илтгэх бичиг баримт
  - 2.8.4 Урьд нь хийж байсан үнэлгээний жагсаалт
  - 2.8.5 Үнэлгээний багийн гишүүдийн товч анкет
  - 2.8.6 Үнэлгээний ажлыг гүйцэтгэх аргачлал, хугацаа, үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг тусгасан санал
- 2.9 Энэ журмын 2.8-т дурьдсан баримт, материалуудыг Ажлын алба хүлээн авч, З-аас доошгүй гишүүнийг байлцуулан задалж, ирүүлсэн баримт бичгийн иж бүрдэлтийг шалган нягталж битүүмжлэн шалгаруулалтын шатанд шилжүүлнэ. Материалаа дутуу бүрдүүлсэн аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулалтад оруулахгүй.
  - 2.10 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ажлын албаны даргын шийдвэрээр холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулж, шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулж болно.
  - 2.11 Ажлын алба ирүүлсэн баримт, саналыг нарийвчлан судалж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гишүүдийн 80-аас доошгүй хувийн бүрэлдэхүүнтэйгээр, нууцаар санал хураан, олонхийн саналаар гүйцэтгэгчийг шалгаруулж, шийдвэр гаргана.
  - 2.12 Ажлын алба сонгон шалгаруулалтын дүнг Зөвлөлийн хуралд танилцуулж Зөвлөлийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал нар гарын үсэг зурж Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тэмдэг дарж баталгаажуулна.
  - 2.13 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбогдон гарсан маргааныг гурвалсан гэрээгээр зохицуулах ба гэрээгээр зохицуулах боломжгүй нөхцөлд шүүхээр шийдвэрлүүлнэ.
  - 2.14 Сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг буцааж олгохгүй.

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Үнэлгээ хийхээр сонгон шалгарсан эрх бүхий гүйцэтгэгч нь дараах эрх эдэлнэ.
  - 3.1.1 Үнэлгээний ажилд шаардлагатай баримт бичгийг ажлын албаар дамжуулан захиалагчаас гаргуулан авах;
  - 3.1.2 Үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажлын байранд нэвтрэх, сорьц, дээж авах;
- 3.2 Үнэлгээ хийхээр сонгон шалгарсан эрх бүхий гүйцэтгэгч нь дараах үүргийг хүлээнэ.
  - 3.2.1 Тухайн орон нутгийн хүн амын эрүүл мэндийн суурь үзүүлэлтийн тоо мэдээг ашиглаж болох бөгөөд холбогдох чиглэлээр нэмэлт судалгаа хийх;
  - 3.2.2 Үнэлгээний тайланг орон нутгийн иргэд, оршин суугчдаар хэлэлцүүлж, албан ёсоор санал авах;
  - 3.2.3 Гурвалсан гэрээ болон ажлын даалгаварт тусгагдсан асуудлыг тайланд бүрэн тусгах;
  - 3.2.4 Гүйцэтгэсэн үнэлгээний үр дүнгийн үнэн зөвийг хариуцах;

- 3.2.5 Захиалагч байгууллагын техник, технологи, бизнестэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалах;
- 3.2.6 Үнэлгээ хийх гүйцэтгэгч нь үнэлгээний ажилтай холбоотой эрсдэлийг Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулна.

ооОоо